

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕС ДЭХ УДААГИЙН СОНГУУЛИАР БАЙГУУЛАГДСАН
УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ
2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9 - 54
1. Анхдугаар чуулганы нээлт	9 - 14
2. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа	14 - 47
3. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай	47 - 54

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн
анхдугаар чуулганы 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-г заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 93 дугаар зарлигаар товлон зарласны дагуу Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулган 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Танхимын зүүн жигүүр болон төв хэсгээр Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр хамгийн олон суудал авсан Монгол Ардын намаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, баруун жигүүрт Ардчилсан намаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, мөн баруун жигүүрт болон төв хэсгээр ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний зориг ногоон намаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд суудлаа эзэлсэн байлаа. Нийт 126 гишүүн хүрэлцэн ирсэн байв.

Танхимын зүүн хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт;

Танхимын баруун хойд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, дэд дарга Ц.Батбаатар;

Зүүн урд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, шалгалт үнэлгээний газрын дарга С.Ганболд, Цахим парламент, инновацын газрын дарга С.Тамир, Парламентын судалгааны хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Гадаад харилцааны хэлтсийн дарга С.Даваадаш, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Б.Батманлай, Хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Болорсүх, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Өргөдөл, гомдол, дүн шинжилгээний хэлтсийн дарга Х.Энэбиш, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Г.Лхагвадорж, Цахим шилжилт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Ч.Эрдэнэчимэг;

Урд талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан;

Баруун урд талд Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга буюу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Э.Түвшинжаргал, Тагнуулын ерөнхий газрын дарга П.Одонбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч Т.Сүхболд, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Г.Байгалмаа, О.Амгаланбаатар, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн нар суудлаа эзэлсэн байв.

Танхимын дээд давхарт Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчид суудлаа эзэлсэн байв.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Батцэцэг, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Бум-Очир, Х.Болормаа, Э.Болормаа, С.Ганбаатар, Д.Ганмаа, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, М.Мандхай, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Ч.Номин, О.Номинчимэг, С.Одонтуяа, Б.Пунсалмаа, Д.Рэгдэл, О.Саранчулуун, М.Сарнай, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Ц.Туваан, Б.Түвшин, Ч.Ундррам, Б.Уянга, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, Л.Энхнасан, Д.Энхтуяа, М.Энхцэцэг нарын гишүүд монгол үндэсний дээл өмссөн байлаа.

“Монгол Улсын Их Хурал” гэсэн бичиг бүхий тэмдэглэлийн дэвтэр, бал, Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль, тогтоолын эмхэтгэл, Улсын Их Хурлын гишүүний гарын авлага, Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм зэргийг хийсэн арьсан хар цүнхийг Улсын Их Хурлын гишүүдийн сандал дээр байрлуулсан байв.

Танхимын баруун хойд, зүүн хойд болон урд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нээлт. 2024.07.02” гэсэн үг гарч байв.

Хуралдааны танхимын гол хэсэгт, индрийн урд соёмбо сийлбэртэй том ширээг цагаан эсгий бүрээстэй сандлын хамт, индрийн баруун талд Төрийн далбааг байрлуулж, өмнө нь цагаан эсгий ширмэл ширдэг дэвсэж, Төрийн сүлдний зүүн, баруун талд хүндэт харуулууд зогссон байлаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танхимд орж ирж, суудалдаа суув.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Б.Батманлай Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийг “Их хуралдай” танхимын урд гол хаалгаар орж ирэхийг зарлан мэдэгдэхэд бүгд босож, алга ташин хүндэтгэл үзүүлэв. /09:59/

Нэг.Анхдугаар чуулганы нээлт

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Б.Батманлай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу Улсын Их Хурлын

анхдугаар чуулганыг нээж Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх үг хэлнэ хэмээн зарлаж, индэрт урив. /10:00/

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх индэрт гарч үг хэлснийхээ дараа Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганыг нээснийг зарлан мэдэгдмэгц Зэвсэгт хүчний Жанжин штабын Бүх цэргийн Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчид Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимын хүлээлгийн хэсгээс эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв. /10:14/

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан баяр хүргэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-г “Анхдугаар чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл тухайн сонгуулиар сонгогдсон насаар хамгийн ахмад гишүүн даргална.” гэж заасны дагуу Дүгэрийн Рэгдэлийг хуралдаан даргалахыг урив. /10:15/

Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл Улсын Их Хурлын даргыг сонгож дуустал анхдугаар чуулганы хуралдааныг даргалав.

Хоёр.Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа

Хуралдаан даргалагч Дүгэрийн Рэгдэл хуралдаан даргалагчийн суудалд суун Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг нээж үг хэлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхэд талархал илэрхийлж, шинээр сонгогдсон гишүүд, анхдугаар чуулганы нээлтийн ажиллагаанд оролцож буй төрийн өндөр болон холбогдох албан тушаалтнууд, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагууд, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн болон Олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгч, зочдод Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг нээсэн түүхэн баярт өдрийн мэндийг хүргэж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөв. /10:16/

Хуралдаан даргалагч Дүгэрийн Рэгдэл Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулийн дүн, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай илтгэлийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран танилцуулна хэмээн зарлаж, индэрт урив. /10:00/

Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулийн дүн, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай илтгэлийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран танилцуулав.

Хуралдаан даргалагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “... насаар хамгийн ахмад гишүүн эхэлж, бусад гишүүн цагаан толгойн үсгийн дарааллын дагуу Улсын Их Хурлын гишүүний тангаргийг уншиж, Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна.” гэж заасны дагуу тангараг өргөхийг онцолж, ёслолын ажиллагаа эхлэв.

Танхимын баруун хойд, зүүн хойд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА. 2024.07.02”, танхимын урд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН БИ АРД ТҮМНИЙХЭЭ ЭЛЧИЙН ХУВЬД НИЙТ ИРГЭН, УЛСЫН АШИГ СОНИРХЛЫГ ЭРХЭМЛЭН, ТӨРТ ЁС, ТҮҮХ, СОЁЛЫНХОО УЛАМЖЛАЛЫГ ХҮНДЭТГЭЖ, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН САХИЖ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙЖ, ГИШҮҮНИЙ ҮҮРГЭЭ ЧИН ШУДАРГААР БИЕЛҮҮЛЭХЭЭ ТАНГАРАГЛАЯ. МИНИЙ БИЕ ЭНЭ ТАНГАРГААСАА НЯЦВАЛ ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭНЭ.” гэсэн Улсын Их Хурлын гишүүний тангаргийн үг гарч байв.

Хуралдаан даргалагч Д.Рэгдэл эхэлж индэрт гаран тангаргийг уншиж, Төрийн сүлдэнд, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нарт мэхийн ёсолж, хүндэтгэл үзүүлсний дараа төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурж, энгэрийн тэмдгээ гардаж авлаа.

Дараа нь суудалдаа сууж, тангараг өргөх гишүүдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар нэг нэгээр нь дуудаж уншив. /10:47-13:20/

Төрийн сүлдний зүүн, баруун талд зогсож байсан Төрийн хамгаалалтын албаны хүндэт харуулуудын ээлж солигдов. /10:56/

Нэр дуудагдсан гишүүд суудлаасаа босож индрээс Улсын Их Хурлын гишүүний тангаргийг уншиж, Төрийн сүлдэнд, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд нарт мэхийн ёсолж, хүндэтгэл үзүүлсний дараа зүүн гар тийш эргэн Төрийн далбааны өмнө байрлах ам цагаан эсгий дээр очиж, зүүн хөлөө урагш нэг алхан баруун өвдөг бохирон сууж Төрийн далбаанаас адис авч, тусгайлан зассан ширээнд суун Монгол Улсын Их Хурлын гишүүний тангаргийн бичигт гарын үсэг зурав.

Улсын Их Хурлын гишүүний энгэрийн тэмдгийг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат гардуулан өгч байв.

Улсын Их Хурлын гишүүдийг Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбаанаас адис авахад Төрийн хамгаалалтын албаны хүндэт харуул ёсолж, хүндэтгэл үзүүлж байв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар “Мөнх хөх тэнгэр Монгол орныг минь ивээж, Монгол Улс мандан бадрах болтугай.” гэсэн үгүүдийг тангараг уншихдаа нэмж хэлсний дараа хуралдаан даргалагч гишүүд тангараг өргөхдөө тангаргийн үгийг өөрчлөх, нэмж үг хэлэхгүй байхыг анхааруулав.

Сүүлийн гишүүн тангаргийг уншиж, Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурж, суудалдаа очмогц Зэвсэгт хүчний Жанжин штабын Бүх цэргийн Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчид Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимын хүлээлгийн хэсгээс эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсад суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөж дууслаа. /13:25/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д “Гишүүн тангараг өргөснөөр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тогтоол баталсанд тооцно.” гэж заасны дагуу “Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. /13:28/

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл “Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /13:29/

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн цаашдын ажилд амжилт хүсэж, баяр хүргэв.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа 13 цаг 29 минутад өндөрлөв.

Гурав. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан нам, эвсэл Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ” гэж заасан, Улсын Их Хурлын 2024 оны ес дэх удаагийн ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 68 суудал авсан Монгол Ардын нам Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэх эрхтэй гэдгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарыг индэрт урив.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хуралд олонхын суудал авсан Монгол Ардын намаас Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурлын гишүүн Дашзэгвийн Амарбаясгалангийн нэрийг дэвшүүлж байгаа тухай саналыг танилцуулав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Улсын Их Хурлын даргыг сонгох санал хураалтыг санал хураалтын төхөөрөмж бүрэн шинэчлэгдсэн, Улсын Их Хурлын гишүүдийн хурууны хээг авч, техникийн тохируулга хийгдэж байгаа тул 2024 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан ес дэх удаагийн Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар хэлэлцэх асуудлын санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу гар өргөж явуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Рэгдэл: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 121
Татгалзсан: 5
Бүгд: 126
96.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Рэгдэл: Монгол Улсын Их Хурлын даргаар Дашзэгвийн Амарбаясгаланг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 121
Татгалзсан: 5
Бүгд: 126
96.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын даргаар Дашзэгвийн Амарбаясгаланг сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. /13:40/

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл “Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг уншиж танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин санал хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /13:45/

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат Төрийн ордны хамгаалалтын хэлтсийн ахлах ажилтны хамгаалалт доор Улсын Их Хурлын тамгыг хадган дээр хүндэтгэлтэйгээр залж ирэхэд, хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл хүлээн авч, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланг гардуулж, суудалдаа залрахыг урив. /13:47/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан суудалдаа суусны дараа иргэд олон нийтэд болон Улсын Их Хурлын нийт гишүүдэд хандан үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нээлтийн хуралдаанд оролцсон Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхэд талархал илэрхийлж, чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулав.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүдийг “Их хуралдай” танхимын хойморт байрлах төрийн сүлдний өмнө болон Төрийн ордны Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлж, дурсгалын зураг авахуулах үйл ажиллагаанд оролцохыг урив.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 55 минут үргэлжилж, 13 цаг 55 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 17 цаг 23 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын тамгыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбатад хадгалуулахаар хүлээлгэн өгөв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг хуралдаж дуусаагүй байгаа тул энэ өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдэв.

Уг асуудлыг 17 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Анхдугаар чуулганы хуралдааныг мэдээллийн mra.mn, eguur.mn, news.mn, itoim.mn, gogo.mn, unnu.news, zindaa.mn сайтуудаар, Монголын Үндэсний олон нийтийн радиогоор, Улсын Их Хурлын Parliament TV онлайн сувгаар шууд дамжуулж, мөн Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн студи, Parliament TV, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэвлэлийн алба, МҮОНТ-ийн “Монголын мэдээ” суваг, Sky Media, Univision, ТМ, EAGLE NEWS, Монгол HDTV, ETV, SBN, TV-9, TV-5, TV-8, C-1, Bloomberg TV, UBS, ETV, MNC, “25 дугаар суваг” телевизүүдээр, Монгол кино нэгтгэл, МОНЦАМЭ агентлаг, Гамма агентлаг, “Зууны мэдээ” сонин, “Өнөөдөр” сонин зэрэг 17 хэвлэл мэдээллийн байгууллагуудын зураглаачид болон өдөр тутмын сонинууд, гэрэл зургийн агентлагуудын 20 гэрэл зурагчин ажиллав.

Анхдугаар чуулганы хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 56 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 126 гишүүн ирж, 100 хувийн ирцтэйгээр 17 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 00 минут

АНХДУГААР ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Нэг. Анхдугаар чуулганы нээлт

У.Хүрэлсүх: “Эрхэм хүндэт ард иргэд ээ, Монгол Улсын Их Хуралд шинээр сонгогдсон эрхэм гишүүд ээ, Эрхэм хүндэт зочид оо,

Монгол төрийн өндөр босгыг давж ард түмнийхээ итгэл, найдварыг хүлээн, өргөн дэмжлэгийг авч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг дээдэлж, эх орон, ард түмнийхээ төлөө хүчин зүтгэхээр төрийн түшээгээр сонгогдсон Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, баяр хүргэж байна. /алга ташив/

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлыг сонгон байгуулж байна.

Монголчууд бид өдгөөгөөс 100 жилийн өмнө анхдугаар Үндсэн хуулиа баталж, хаант засаг, хамжлагат ёсыг халж, Бүгд найрамдах засгийг сонгон, эрэгтэй, эмэгтэй хүн адил тэгш эрхтэй байж, сонгох, сонгогдох эрхээ баталгаажуулж байсан бахдам сайхан түүхтэй ард түмэн.

Улмаар 1992 онд Ардчилсан шинэ Үндсэн хуулиа батлан тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө, ардчиллын зарчмыг бататган бэхжүүлж, парламентын ес дэх удаагийн сонгуулиа амжилттай зохион байгуулан, Үндсэн хуулийн өөрчлөлтөөр баталгаажсан 126 гишүүнтэй анхны Улсын Их Хурал ийнхүү байгуулагдаж байна.

Энэ удаагийн Улсын Их Хурлын сонгуульд 19 нам, 2 эвсэл, 42 бие даагч иргэн буюу нийт 1341 нэр дэвшигч өрсөлдөж, ардчилсан Монгол Улсын сонгуулийг ажиглахаар гадаадын 21 байгууллагын 40 гаруй орны 259 ажиглагч, мөн дотоодын 30 орчим мянган ажиглагч сонгуулийн үйл явцад хяналт тавин ажиллалаа.

Улсын Их Хурлын ес дэх удаагийн энэ сонгуульд манай ард иргэд ардчилсан Монгол орныхоо бүрэн эрхт эзэн нь байж, урьд өмнөхөөсөө илүү өргөн оролцоотойгоор сонгох, сонгогдох эрхээ бас эдэллээ.

Төрт ёсны аугаа түүхтэй, Азийн цээжин дэх ардчилсан Монгол Улсын төрийн сонгууль хуулийн хүрээнд,

ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг ханган амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ баталгаажуулан, төрийн эрх барих дээд байгууллагын төлөөлөгчдөө сонгох сонгуульд идэвхтэй оролцсон нийт иргэд, сонгогчдодоо болон хилийн чанадад суугаа монголчууддаа гүн талархал илэрхийлж бас Та бүхний нэрийн өмнөөс талархал дэвшүүлж байна. /алга ташив/

Мөн ард иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхийг эдлэх нөхцөл, боломжийг хангаж, хуулийн хүрээнд амжилттай сайн ажилласан Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн бүх шатны хороодод ажилласан 40 гаруй мянган төрийн алба хаагч болон сонгуулийн мэдээ мэдээллийг түргэн шуурхай, ил тод, цаг алдалгүй түгээн ажилласан гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн ажилтнууддаа бас гүн талархал илэрхийлье. /алга ташив/

Эрхэм хүндэт төрийн түшээд ээ,

Өргөн түмнийхээ итгэлийг хүлээж, өндөр төрийнхөө түшээгээр сонгогдсон Та бүхэн Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу төр засгаа эмхлэн байгуулж, түмэн олныхоо төлөөх эрхэм үйл хэрэгтээ цаг алдалгүй шамдан ажиллах шаардлагатай байна.

Энэ мөчөөс эхлэн төрийн түшээд Та бүхэн хувийн ашиг сонирхлоос ангид байж, нийт ард иргэд, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, төр, түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнч байж, амласан амлалтаа биелүүлэх цаг

хугацаа ийнхүү эхэлж байгааг би бас цохон тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Улсын Их Хурлын энэхүү эрхэм танхимд хувь хүний хэрүүл маргаан биш, улс орны хөгжил дэвшлийн төлөөх бодлогын мэтгэлцээн өрнөж, хувийн явцуу эрх ашиг биш, улс орны язгуур эрх ашгийн төлөөх бодлогын хэлэлцүүлэг өрнөдөг байх учиртай.

Үүнийг ч ард түмэн Та бүхнээс хатуу шаардах болно.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, албан тушаалын уг сурвалж нь ард түмнээс эхтэй гэдгийг Та бүхэн маань ямагт санаж яваарай.

Парламент бол ард түмний хураангуй. Та бүхэн бол ард түмний төлөөлөл, төр, засаг, түмэн олныг холбох гүүр юм шүү гэдгийг огт мартаж болохгүй.

“Хүн нэрээ, тогос өдөө” гэж ардын сайхан үг байдаг.

Улсын Их Хурлын гишүүн, төрийн түшээ гэсэн энэхүү эрхэм хүндтэй нэр хүндийг Та бүхэн нэр төртэй, өндөрт өргөн, хариуцлагатай авч явахыг хүсье.

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хүн төрөлхтөн, дэлхий нийтээрээ цар тахал, геополитикийн зөрчил, мөргөлдөөн гээд амаргүй цаг үеийг бид хамтдаа тууллаа.

Монголчууд биднээс үл хамаарах хүндрэл, бэрхшээлүүд улс орны эдийн засаг, ард түмний амьдрал ахуйд ч бас хүндээр нөлөөлж байсан.

Хэдийгээр нөхцөл байдал амаргүй байсан ч гэсэн манай төр, засаг, ард

түмэн, баялаг бүтээгчидтэйгээ хамтран энэхүү хүнд үеийг хохирол багатай даван туулж, энэ оны эхний улирлын байдлаар улсынхаа эдийн засгийг 7.8 хувиар өсгөж чадсан байна.

Шинээр бүрдэж буй Улсын Их Хурал, Засгийн газар энэхүү эдийн засгийн өсөлтийг улам баталгаажуулан, үр шимийг нь өрх бүрд хүргэж, монгол хүн бүрийн аж амьдралд бодит үр өгөөжөө өгсөн эдийн засгийн бодлогыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол хүн эх орон, газар нутагтаа эзэн байж, байгалийн баялгийнхаа үр шимийг адил тэгш хүртэх учиртай.

Монгол хүн, монголын ард түмэн хэзээ ч эх орон, байгалийн баялгаа бусдад алдах ёсгүй.

Эх орондоо эзэн байна гэдэг бол байгалийн баялагтаа эзэн байна гэсэн үг.

Баялагтаа эзэн монголын төлөө төр засаг, түмэн олноороо бид хамтран тэмцэж, зүтгэх хэрэгтэй.

Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиас эхтэй Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж чадсан нь байгалийн баялгаа төр, ард түмнийхээ мэдэлд байлгаж, үр шимийг нь иргэн бүр тэгш хүртэх эрх зүйн шинэчлэл, тогтолцооны өөрчлөлтийн эхлэлийг тавьж чадлаа.

Энэхүү Баялгийн сангийн үр өгөөжийг нэн тэргүүнд ард иргэдийнхээ боловсрол, эрүүл мэнд, орон байрыг шийдэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглүүлэх учиртай гэж үзэж байна.

Энэ нь харьцангуй залуу ард иргэдтэй манай улсын хувьд ирээдүй хойч үедээ оруулж буй үнэт өв, өвлүүлэн үлдээх бодит хөрөнгө оруулалт болох юм.

Өнгөрсөн 100 жил монголчууд бидний хувьд улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдөж, орчин цагийн ардчилсан Монгол Улсыг цогцлоон байгуулсан “Тусгаар тогтнол, хөгжил дэвшил”-ийн аугаа зуун байсан.

Харин энэ зуун бол монголчууд бидний хувьд ардчилсан төр улсаа улам хөгжүүлж, “Их бүтээн байгуулалт, эдийн засгийн аюулгүй байдлаа ханган бэхжүүлсэн зуун” байх учиртай.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч “100 жил – 10 зорилт” хөгжлийн санаачилгыг дэвшүүлснийг бас Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Энэ хүрээнд улс орны аюулгүй байдал, оршин тогтнохуйн үндэс болсон байгаль орчин, үндэсний үйлдвэрлэл, стратегийн ордууддаа онцгой анхаарч, хүнс, эрчим хүч, нефть, шатахуунаар дотоодын хэрэгцээг хангах, аж үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлж, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Нэн ялангуяа хүнд болон хөнгөн үйлдвэрийн цогцолборуудыг ашиглалтад оруулах, дэд бүтэц, төмөр зам, транзит тээвэр, хил боомтоо хөгжүүлэх зэрэг их бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг шуурхайлан ажиллах ёстой.

Мөн Монгол Улсын
Ерөнхийлөгчийн санаачилсан

- “Хүнсний хувьсгал”,
- “Тэрбум мод”,
- “Эрүүл Монгол хүн”,
- “Цагаан алт”

зэрэг өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой үндэсний хөтөлбөрүүд, Шинэ Хархорум хотыг сэргээн байгуулах их бүтээн байгуулалтын ажлыг шинэ Улсын Их Хурал, Засгийн газар бодит ажил хэрэг болгох ёстой юм.

Төрийн тэргүүн ард түмнийхээ нэрийн өмнөөс Та бүхний үйл ажиллагаанд хяналт тавьж, шахаж, шаардаж, бодит үр дүн нэхэж ажиллах болно гэдгээ анхдугаар чуулганы энэхүү эрхэм индрээс бас сануулж байна.

Эрхэм нөхөд өө,

Монгол Улсын Ерөнхийлөгч нийгэмд шударга ёс тогтоохын төлөө хүн засагладаггүй хууль засагладаг ардчилсан, шударга төрийг жинхэнэ утгаар нь байгуулахын төлөө хичээн зүтгэж ажиллана гэдгээ ард түмэндээ хэлснийг Та бүхэн мэдэж байгаа.

Нийгэмд шударга ёсыг тогтоох нь Улсын Их Хурал, Засгийн газрын үндсэн чиглэл, ард иргэдийн итгэл найдвар, Та бүхний хүлээх үүрэг, даалгавар байх учиртай.

Нийгэмд шударга ёс тогтоох үндсэн суурь нь хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байж, хууль ёс хүн бүрд тэгш үйлчлэх явдал юм.

Төрд зүтгэж буй хэн боловч төгс сайн мэдлэггүй ч төгөлдөр сайн ёс суртахуунтай байх ёстой.

Ард түмний төлөөлөл болсон Та бүхэн ёс зүйн дээд манлайллыг ямагт үзүүлж байх ёстой гэдгийг цохон тэмдэглэе.

Ард иргэдийнхээ халуун итгэл, их хүлээлт дунд парламентын гишүүнээр сонгогдсон Та бүхэн хүний ёсыг огоорон ёс зүйн алдаа гаргаж, өргөсөн тангаргаасаа няцвал ард иргэдээсээ уучлалт гуйн, нэн даруй өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх ёстойг би энэ өдөр анхааруулан хэлэхийг хүсэж байна.

“Төр төмбөгөр, ёс ёмбогор” гэж манай ардын сайхан үг байдаг.

Төрийн сүлд, ард түмэндээ өргөсөн тангаргаа зөрчсөн хэн боловч ард түмний төлөөлөл болон энэхүү эрхэм хүндтэй танхимд суух учиргүй шүү.

Иймд энэ удаагийн Улсын Их Хурал ёс зүй, сахилга хариуцлагыг дээдлэн сахиж, ард түмний сонголтыг хүндэтгэн, парламентын нэр хүндийг өндөрт өргөж, аливаа ашиг сонирхол, гэмт хэрэг, хэрэг зөрчлөөс ангид байж, сонгогч олныхоо итгэл найдварыг дааж, нэр төртэй ажиллахыг Төрийн тэргүүн онцгойлон сануулж байна.

Хууль хяналтын байгууллагын удирдлагууд ч гэсэн хуульд захирагдан бурууд нүд хурц байж, гэмгүй нэгнийг хэлмэгдүүлж болохгүй, гэмт хэрэгтэнд ял завшуулж болохгүй гэдгийг би бас дахин анхааруулж хэлье.

Та бүхэн өнөөдрөөс эхлэн ард түмний элчийн хувиар нийт иргэн, улсын ашиг сонирхол, Үндсэн хуульд захирагдан ажиллахаар эх орон, ард түмнийхээ өмнө тангараг өргөж байна.

Монгол төрийн алтан соёмбот далбаанд тангараг өргөсөн энэ цаг мөчөөс эхлэн дараах зүйлсийг онцгой анхаарч, хүлцэн тэвчих учиртайг бас хэлье.

Сонгуулийн үеийнх шиг намчирхан талцаж, хий хоосон улс төржиж, хийрхэлгүйгээр эвийг эрхэмлэн, зөвийг дэмжин, эвлэн нийлж, эх орон, ард түмнийхээ төлөө итгэл дааж, сэтгэл гаргаж, хичээн зүтгэвэл зохилтой.

Иймд энэ удаагийн Улсын Их Хурал аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ монгол төрийн бодлогын залгамж чанарыг сайтар хадгалан, ард түмнийхээ санал бодлыг сайтар судалж, шинжлэх ухаанчаар асуудалд ханддаж, хэлсэн үгэндээ эзэн болж, эв эе, эвлэрэл зохицлыг эрхэмлэн, бие биедээ хүндэтгэлтэй хандаж, уян хатан байж, уур уцаараар бус ухаан бодлоор асуудалд хандаж шийдвэр гаргаж байхыг онцгойлон анхаарах ёстой.

Энэ бол өргөн олон түмний сонголтоос урган гарч байгаа ард түмний зүй ёсны бодит шаардлага гэдгийг Та бүхэн маань хүлээж авах ёстой.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжин тэлж, өндөр, дээд түвшний харилцан айлчлалуудын давтамж нэмэгдэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн орон болох 192 улстай Монгол Улс дипломат харилцаа тогтоож, Монгол Улсын нэр хүнд олон улсын тавцанд өсөн бэхжиж, байр сууриа улам бататгасан түүхэн он жилүүд болж байна.

Цаашид улс орны аюулгүй байдал, гадаад харилцааны асуудалд нэг бодлого, нэгдмэл байр суурьтай байх ёстой.

Аюулгүй байдал, гадаад харилцааг улс төржүүлж огт болохгүй. Бас хийрхэж болохгүй.

Улсын аюулгүй байдал, гадаад бодлого гэж байхаас Улсын Их Хурлын гишүүний бие даасан гадаад бодлого гэж огт байхгүй гэдгийг бас сайн бодож байх хэрэгтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч үзэл санаа, үйл хэрэгтээ ямагт баримталж, цаг ямагт сэтгэлээ чилээдэг улс үндэстний оршин тогтнохуйн тулгуур гурван үнэт зүйл байдаг юм.

Энэ бол манай улсын тусгаар тогтнол. Манай улсын аюулгүй байдал, үндэстний аюулгүй байдал, манай ард түмний эв нэгдэл гэсэн гурван асуудал байна.

Эрхэм төрийн түшээд Та бүхэн ч бас энэхүү гурван үнэт зүйлийг төрийн үйл хэрэг шийдэхдээ цаг ямагт санаж, эрхэмлэн дээдэлж, чандлан баримталж, нүдний цөцгий мэт хайрлаж хамгаалж явах учиртай юм шүү.

Монгол төрийн эрхэм түшээд Та бүхэн үндэстний язгуур эрх ашгийг дээдлэн сахиж, эзэн Чингис хааны билиг сургаалыг даган мөрдөж, ард түмнийхээ эв нэгдлийг сахин бататгаж, халуун зуураа эе эвээ хичээн, эх орныхоо хөгжил дэвшил, улс монголынхоо ирээдүйн сайн сайхны төлөө хичээн зүтгэх ёстой.

Бид нэг монгол, нэг гэр бүл, нэг ард түмэн гэдгээ гүнээ ухамсарлаж, хүсэл зорилго, үнэт зүйлээрээ нэгдэн нийлж, хотол түмнээрээ сэтгэлээ төвшитгөн, итгэлээ бэхэлж, эвээ зангидан, өөдрөг тэмүүлэл, өрнүүн зүтгэлээр эх орноо хамтдаа хөгжүүлцгээе.

Төр түвшин, шашин тунгалаг,
дэлхий амгалан байх болтугай.

Мөнх тэнгэрийн хүчин дор
Монгол Улс мандан бадрах болтугай”
/алга ташив/

(Улсын Их Хурлын анхдугаар
чуулганыг нээж Монгол Улсын
Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх үг хэлж
Анхдугаар чуулган нээснийг зарлан
мэдэгдмэгц Төрийн дуулал танхимд
эгшиглэв.)

Хоёр.Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа

Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуульд заасны дагуу Анхдугаар чуулганы
хуралдааныг Улсын Их Хурлын даргыг
сонгох хүртэл тухайн сонгуулиар
сонгогдсон насаар хамгийн ахмад гишүүн
даргална гэж заасан тул Улсын Их
Хурлын гишүүнээр сонгогдсон Дүгэрийн
Рэгдэл Таныг хуралдаан даргалахаар
урьж байна. /алга ташив/

Д.Рэгдэл: Улсын Их Хурлын
анхдугаар чуулганыг нээж үг хэлсэн
Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн
Хүрэлсүх Танд их баярлалаа.

Монгол Улсын эрхэм
Ерөнхийлөгч өө,

Эрхэмсэг хатагтай, ноёд оо,

Та бүхэндээ Улсын Их Хурлын
анхдугаар чуулган нээсэн энэ түүхэн
баярт өдрийн мэндийг хүргэж, сайн
сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. /алга
ташив/

Одоо Монгол Улсын Их Хурлын
ес дэх удаагийн сонгуулийн дүн,
сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг
хүлээн зөвшөөрөх тухай илтгэлийг

Сонгуулийн ерөнхий хорооны дарга
Пүрэвээгийн Дэлгэрнарэн танилцуулна.

П.Дэлгэрнарэн дарга таныг индэрт
урья.

П.Дэлгэрнарэн: Эрхэм хүндэт
Монгол Улсын Ерөнхийлөгч өө,

Эрхэм хүндэт Ерөнхий сайд аа,

Сонгогчдынхоо итгэлийг хүлээж
Улсын Их Хуралд сонгогдсон эрхэм
гишүүд ээ,

Хатагтай, ноёд оо,

Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо хуульд заасан бүрэн
эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их
Хурлын ес дэх удаагийн сонгуулийг
Монгол Улсын Үндсэн хууль,
Сонгуулийн төв байгууллагын тухай
хууль, Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тухай хууль, Сонгуулийн
автоматжуулсан системийн тухай хууль
болон холбогдох бусад хууль
тогтоомжийн дагуу 2024 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр амжилттай зохион
байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу гадаад улсад байгаа сонгогчдынхоо санал авах ажлыг гадаадын 33 улсын 47 дипломат төлөөлөгчийн газарт 06 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд мөн амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэн Монгол төрийнхөө эрхийг барих дээд байгууллагадаа төлөөллөө сонгох сонгуульдаа идэвхтэй оролцсон нийт сонгогчдодоо гүн талархал илэрхийлье.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны энэ удаагийн ээлжит сонгууль нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу анх удаа Улсын Их Хурлын 126 гишүүнийг сонгуулийн хосолсон тогтолцоогоор зохион байгуулж явуулсан нь сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагааны хувьд өргөн цар хүрээг хамарсан онцлогтой боллоо.

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоор нийт 19 нам, 2 эвсэл, нийт 1341 нэр дэвшигч бүртгүүлсэн нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн түүхэнд хамгийн олон нам, эвсэл, нэр дэвшигч оролцсон сонгууль боллоо.

Тухайлбал, 19 нам, 2 эвслээс сонгуулийн тойрогт 927, жагсаалтаар 372, бие дааж 42 нэр дэвшигч бүртгүүлсэн бөгөөд нийт нэр дэвшигчдийн 61.3 хувь нь буюу 821 нь эрэгтэй, 520 буюу 38.7 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байлаа.

Сонгуулийн тогтолцооны энэхүү онцлог, түүнтэй холбоотойгоор олон нам, эвсэл, нэр дэвшигч сонгуульд оролцсон нь Сонгуулийн ерөнхий хорооны хувьд сонгууль зохион байгуулах үйл

ажиллагаа болон сонгогчдод мэдээлэл хүргэх, сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг оновчтой төлөвлөж зохион байгуулах шинэ сорилт боллоо.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа нь хэн, хэзээ, юуг, хэрхэн хийсэн байхыг нарийвчлан тогтоож өгсөн сонгуулийн процессын эрх зүйгээр зохицуулагддаг онцлогтой байдаг.

Энэхүү онцлогт нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах бүх үйл ажиллагааг иргэд сонгогчид болон сонгуульд оролцож буй нам, эвсэлд нэр дэвшигчдийн зүгээс хөндлөнгийн хяналт тавих боломжийг бүрдүүлэн, нээлттэй, ил тод зохион байгуулахад онцгой анхаарлаа.

Сонгуульд оролцогч талуудаас гаргасан сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэл, түүний системийн үйл ажиллагаатай танилцах, хөндлөнгийн хяналт хийх, сонгуулийн бэлтгэл ажлын явцыг сайжруулах болон сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн үйл явцын талаарх мэдээ, мэдээллийг өргөн хүрээнд зохион байгуулах, мөн сонгуулийн автоматжуулсан техник хэрэгслийн үйл ажиллагааг шалган турших чиглэлээр гаргаж буй санал, санаачилга, шаардлагыг хуулийн хүрээнд дэмжиж, нээлттэй хамтран ажиллалаа.

Сонгогчдын эргэлзээ төрүүлсэн, төөрөгдөлд оруулсан баримтгүй, худал мэдээллийг сонгуульд оролцогч талуудын олон нийтэд түгээхээс өмнө тухайн мэдээллийн эх сурвалжийг нягтлан шалгаж, бодит баримтад үндэслэсэн гомдол, шаардлага, санал санаачилга гаргах шаардлагатай юм.

Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн эсэх гомдол мэдээллийг Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу цагдаа, тагнуул, шүүх зэрэг нийт 9 эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд хянан шийдвэрлэхээр хуульчилсан бөгөөд цагдаагийн байгууллагад 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш нийслэлд 756, орон нутагт 504, нийт 1260 гомдол, мэдээлэл бүрдэгдсэн байна.

Эдгээр гомдол, мэдээллийг харьяаллын дагуу холбогдох нэгжүүдэд шалгалтын ажиллагаа явуулж ажилласан байна.

Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулийг зохион байгуулахад аймаг, нийслэлийн 22 сонгуулийн хороо, сум, дүүргийн 339 сонгуулийн хороо, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв комисс болон 47 салбар комисс, 2198 хэсгийн хороонд нийт 21 мянга 943 төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч, мэдээллийн технологийн 2763 албан хаагч ажилласнаас гадна онцгой нөхцөл байдалд сонгогчдын санал авах ажилд онцгой байдлын албанаас 530 гаруй албан хаагч, эрүүл мэндийн мянга гаруй ажилтан ажиллалаа.

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, давхардлыг арилгах, нягтлан шалгах үйл ажиллагаатай холбоотойгоор 3 мянга 474 иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, сонгуулийн үйл ажиллагааны үед гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн 12 мянга орчим албан хаагчийн үүрэг гүйцэтгэж, Төрийн тусгай хамгаалалтын газрын албан хаагчид бүрэн

бүрэлдэхүүнээрээ ажиллаж, нийтдээ 41 мянга 689 төрийн албан хаагч хуулиар хүлээсэн чиг үүргээ нэр төртэй биелүүлж ажиллалаа.

Мөн энэ удаагийн сонгуулиар анх удаа хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод сонгох эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах сайн дурын ажилтныг нийслэлийн дүүргүүдэд ажиллууллаа.

Энэ удаагийн сонгуулиар санал хураалтын дүнг сүлжээний үндсэн дэд бүтцээс хамааран сүлжээт газар зөөвөрлөж дамжуулдаг нийт 600 гаруй хэсэгт Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран 419 ширхэг сансрын холбооны шинэ шийдэл, шинэ төхөөрөмж ашиглан дүнг шуурхай дамжуулах ажлыг улсын бүртгэлийн болон сонгуулийн байгууллагын мэдээлэл технологийн баг даамлууд амжилттай зохион байгууллаа.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг хуулийн дагуу, ил тод, шударга зохион байгуулахад хүчин зүтгэл гарган ажилласан нийт албан хаагчдадаа Сонгуулийн ерөнхий хорооны нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон Улсын Их Хурлын 2023 оны 113 дугаар тогтоолд заасны дагуу сонгуулийн автоматжуулсан системээр амжилттай зохион байгуулж явууллаа.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7, 65 дугаар зүйлийн 65.16-д заасны дагуу санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнг нэгтгэн шууд дамжуулах, сонгогчийн ирц бүртгэлийг мөн шууд дамжуулах, камерын нэгдсэн

хяналтын сүлжээгээр дамжуулан сонгогчдын саналаас бусад бүх үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангах зэрэг технологийн шийдлийг амжилттай хэрэгжүүлээ.

Тагнуулын ерөнхий газар, Цахим хөгжил, харилцаа, холбооны яам болон Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн хамтарсан ажлын хэсэг, санал тоолох төхөөрөмж, бүртгэлийн техник хэрэгслийг хуульд заасны дагуу нэг бүрчлэн шалган туршиж баталгаажуулан гэрчилгээ олгож ажилласан болно.

Сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгслийг хоёр үе шаттайгаар нэг бүрчлэн шалган туршиж, гэрчилгээ олгох үйл ажиллагааг сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч, иргэдийн зүгээс Монгол Улсын хэмжээнд ажилласан бүх төхөөрөмжид хөндлөнгийн хяналт тавих, шалгах, турших үйл ажиллагааг нээлттэй зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын энэ удаагийн сонгуулийн үйл ажиллагаа дэлхий дахин анхааралтай ажиглаж, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагууд сурвалжлан олон улсад Монгол Улс, Монголын сонгуулийн талаарх мэдээллийг шуурхай түгээн ажиллалаа.

Тухайлбал гадаадын болон олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн нийт 15 байгууллагын 36 сэтгүүлч, сурвалжлагчид Гадаад харилцааны яаманд бүртгүүлэн сонгуулийг сурвалжилж ажиллалаа.

Мөн энэ удаагийн сонгуулийг ажиглахаар гадаадын болон олон улсын байгууллага, Монгол Улсад суугаа гадаад

орнуудын Элчин сайдын яамдаас ажиглалт хийн үнэлэлт дүгнэлт танилцуулж эхэллээ.

Тухайлбал, Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны сонгууль ажиглах тусгай багийн 29 орны. Энд Америкийн Нэгдсэн Улс, Серби, Унгар, Грек, Словак, Польш, Монтенегро, Тажикстан, Орос, Казахстан, Узбекистан, Герман, Австри, Ирланд, Итали, Чех, Франц, Норвег, Нидерланд, Швед, Дани, Албани, Умард Македони, Болгар, Азербайжан, Эстони, Финлянд, Румын, Испани зэрэг улсуудаас 187 ажиглагч Дэлхийн сонгуулийн байгууллагын холбооны 3 ажиглагч, Филиппин, Энэтхэг, Узбекистан, Казахстан, Орос, Гүрж, Киргиз Улсын Сонгуулийн төв байгууллагын 16 ажиглагч, мөн Их Британи, Америкийн Нэгдсэн Улс, Япон, Австрали, Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдын 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиглагчдын баг ажигласнаас гадна манай улсад үйл ажиллагаа явуулж буй Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Конрад Аденауэрын сан, Бритиш Колумбын их сургууль, Бодлого, залуучуудын хяналт зэрэг 249 ажиглагч сонгуулийг ажиглалаа.

Энэ удаагийн сонгуулийг ажигласан олон улсын байгууллагад хөндлөнгийн дүгнэлтүүдээ гаргаж эхлээд байна.

Тухайлбал, Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны сонгууль ажиглах тусгай баг урьдчилсан дүгнэлттээ сонгуулийн байгууллага сонгогчдын боловсролын иж бүрэн хөтөлбөр

хэрэгжүүлж, олон нийтийн итгэлийг хүлээж, мэргэжлийн түвшинд ажилласан.

Сонгуулийн ерөнхий хороо мэргэжлийн ил тод байдлаар ажиллаж, өрсөлдөгчид болон ажиглагчдад нээлттэй хандсан төдийгүй олон улсын сонгууль ажиглах хорооны уулзсан хүмүүсийн дийлэнх нь бүх шатын сонгууль зохион байгуулах байгууллагад итгэдгээ илэрхийлсэн юм.

Сонгуулийн ерөнхий хороо ирцийн мэдээллийг өдрийн турш үзүүлж, санал өгөх хугацаа дуусмагц сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн нь сонгуулийн ил тод байдалд чухал нэмэр оруулсан гэдгийг онцолсон юм.

Сонгогчдыг мэдээллээр хангах, сонгуулийн үйл явцыг сурвалжилж, мэдээ мэдээллийг шуурхай түгээхэд хувь нэмрээ оруулахаар дотоодын 434 хэвлэл мэдээллийн байгууллагын 4600 гаруй сэтгүүлч, зураглаач, инженер, техникийн ажилтнууд хүчин зүтгэл гаргаж идэвхийлэн ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, сонгуулийн шинэ тогтолцоо, сонгуулийн тойрог, мандат, санал тэмдэглэх заавар, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаа зэрэг олон шинэ зохицуулалтыг сонгогчдод таниулах, сурталчлах, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах ажлыг тогтмол мэдээлэл авдаг тухайн мэдээллийн хэрэгслээр нь дамжуулан уламжлалт арга хэлбэрт баригдахгүйгээр өргөн хүрээнд зохион байгуулахад Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс онцгой анхаарч, хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус

байгууллагуудтай нээлттэй хамтран ажилласан.

Сонгуулийн үйл ажиллагааг шуурхай, нээлттэй, амжилттай зохион байгуулж сонгогчдод сонгуулийн боловсрол олгоход хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагууд төрийн бус байгууллага, сонгуулийн зүтгэлтнүүд Та бүхэндээ талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдээс санал авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд Монгол Улсын сонгуулийн түүхэнд гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн сонгуулийн идэвх оролцоо нэмэгдэж, саналаа өгөхөөр бүртгүүлсэн нийт сонгогчдын 73.2 хувь нь сонгуульд оролцсон эерэг нөлөөг үзүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн, бүрэн эрх нь дуусгавар болж буй парламентын дарга, гишүүдэд талархал илэрхийлж байгаагаа илэрхийлье. /алга ташив/

Цаашид бид сонгууль зохион байгуулахад тодорхой хэд хэдэн чиглэлээр анхаарч ажиллах шаардлага үүсэж байгааг онцлон тэмдэглэж байна.

Тухайлбал, санал авах ажиллагааг тодорхой хугацаанд урьдчилан авах, хэсэгчлэн цахимжуулах зэргээр сонгогчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, сонгуулийн

автоматжуулсан системийн техник, технологийн шинэчлэлтэй холбоотой шийдвэр гаргаж, сонгох эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоог сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Санал авах ажиллагааны цахим системийн оновчтой шийдлийг нэмэгдүүлж, хэсэгчлэн нэвтрүүлснээр саналаа өгөхөд хүндрэл үүсдэг зарим асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

